**САНАМЖ**
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ үү.
- Өгсөн зайд цэвэр гаргацтай бичээрэй.

1. 12 болон 18 – ын хуваагчдыг Эйлер – Веннийн диаграммаар дүрсэлжээ.
Диаграммыг ажиглаад, өгүүлбэрүүдийн үнэн, худлыг тодорхойлно уу.




| Өгүүлбэр | үнэн | худал |
|---|---|---|
| 12-ын хуваагчид нь зөвхөн 4,12 | | |
| 6 нь 12 болон 18-ын ерөнхий хуваагч | | |

2. Будсан хэсэг нь $\frac{4}{6}$ - тэй тэнцүү байх дүрсийг сонгож, дугуйлаарай.




3. Зурагт харуулсан куб хэлбэртэй саванд хэдэн литр ус багтахыг тооцож, сонгоорой.




А. 10 л Б. 1 л
В. 100 л Г. 1000 л

4. А хотоос гарч, заавал В хотоор дамжин С хотод очихоор болов. Нийт хэдэн ялгаатай замаар явж болохыг тооцоод, сонгоорой.




А. 4 Б. 20
В. 12 Г. 15

5. Дараах биетүүдээс ирмэгийн тоо нь 9 байх биетийг сонгоорой.

А.

Б.

В.

Г.


**6**

Тэгшитгэл зохиож бодоорой.

Хуваагч нь 84, ногдвор нь 11450, үлдэгдэл нь 48 бол хуваагдагчийг олоорой.

**7**

Тавдугаар ангийн сурагчдын $\frac{1}{4}$ нь шатар, $\frac{1}{3}$ нь бүжиг, $\frac{5}{12}$ нь гар бөмбөгийн дугуйланд суралцдаг байна.

А. Аль дугуйланд хамгийн олон сурагч хамрагддаг вэ?

Б. Хэрэв бүжгийн дугуйланд 96 сурагч суралцдаг бол нийт хэдэн сурагч дугуйланд хамрагддаг вэ?

**8**

Координатын хавтгай дахь $A, B, C$ цэгүүдийг дараалан холбож гурвалжин үүсгэжээ.




А. $C$ цэгийн координатыг бичээрэй.

$C(\square;\square)$

Б. $ABC$ гурвалжныг $B$ оройд төвтэй, цагийн зүүний эсрэг $90°$ - аар эргүүлээрэй.

9 Хүснэгтэд 100 г гүзээлзгэнэд агуулагдах шим бодисын хэмжээг харуулав.

| *Шим бодис* | Хэмжээ *(100 г)* |
|---|---|
| уураг | 0.8 г |
| өөх тос | 0.4 г |
| нүүрс ус | 7.4 г |



Охин 300 г гүзээлзгэнэ идсэн бол түүний авсан нүүрс усны хэмжээ нь уураг болон өөх тосны нийлбэрээс хэдэн граммаар их байна вэ?

10 Хүү номуудыг хайрцагт хийхээр болов. Хайрцаг болон номын хэмжээг зургаар өгсөн байна. Хайрцагт хэдэн ном багтах вэ?

